



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 1/19

Хэрлэн сум

Мал сүрэгт үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.16, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Сумын бог малын хээлтүүлэгч, цөм сүргээр бүртгэгдсэн мал, Галшар сумын улаан ямаа, Дадал сумын үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын хэсгийг захирамжаар томилон, хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Сумдын Мал эмнэлэг үржлийн тасаг, мал үржлийн аж ахуйн нэгжийн мал сүрэгт хийх үзлэг ангилалтын ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/ нарт үүрэг болгосугай.
4. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын нэгдсэн дүнг Улсын мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 960

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 15 өдрийн 4/191
дугаар захирамжийн хавсралт



МАЛ СҮРЭГТ ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙЖ, ЦӨМ СҮРЭГ
БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Хэрлэнчулуун	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Гантөмөр	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга
Гишүүд:	Ж.Энх-Амгалан	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Б.Мөнхжаргал	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Сүнгээ	-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга